



## ҮНДЭСЛЭЛ

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, 35.2, 35.3 дахь хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Стандартчилал хэмжил зүйн газраас баталсан “Хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6040:2019” стандарт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/116 дугаар тушаалаар “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх, журам, Нийгмийн хамгааллын, Хууль зүйн, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар А/80, А/132, А/60 “Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх” журам, Нийгмийн хамгааллын, Хууль зүйн, Эрүүл мэндийн сайдын А/173, А/251, А/3801 тоот хамтарсан тушаалаар “Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх” журам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/73 тоот тушаалаар “Холбон зуучлах үйлчилгээ”-ний журам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/39 тоот тушаалаар “Монголын Нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм”-ийг тус тус батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Улсын хэмжээнд 16 Түр хамгаалах байр, 14 Нэг цэгийн үйлчилгээний төв хохирогчийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Цаашид хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор 5 Түр хамгаалах байр шинээр байгуулагдана.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр гарсан дүрэм, журмуудын хэрэгжилтэд мэдэгдэхүйц ахиц амжилт гарч байгаа хэдий ч Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байрны зүгээс Хамтарсан багтай ажиллах, шаардлагатай тохиолдолд хохирогчийг бусад үйлчилгээнд холбон зуучлах, үйлчилгээнд тавигдах ёс зүйн хэм хэмжээ, зарчмуудыг тогтоох, түүнийг хэрхэн баримтлах талаар гарсан гарын авлага, дүрэм, журам одоогоор байхгүй байна.

Хамтарсан баг нь өрхийн эмч, сум, хороо, сургуулийн, халамжийн, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэх бөгөөд Хамтарсан багийг тухайн сум, хорооны Засаг дарга ахалж хуулийн дагуу ажиллаж байна.

## ЗОРИЛГО

Хүчирхийллийн хохирогчдод зориулсан Нэг цэгийн үйлчилгээний төвөөс хамтарсан багтай ажиллах удирдамж, хохирогчийг бусад шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах удирдамж, үйлчилгээнд тавигдах ёс зүйн зарчмуудын төслийг боловсруулах.



Зөвлөх баг нь дараах ажлыг гүйцэтгэх ба ажлын нарийвчилсан төлөвлөгөөг хавсралтаар батлуулна.

1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т заасан “Нэг цэгийн үйлчилгээ”-ний өнөөгийн нөхцөл байдал, хуулийн хэрэгжилтийн талаар дүн шинжилгээ хийнэ.
2. Хамтарсан баг болон Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйлчилгээний онцлог, үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээг тодорхойлох судалгаа хийнэ.
3. Хамтарсан баг болон Нэг цэгийн үйлчилгээний төвийн ажилтнуудын ажлын байрны шинжилгээ ба тодорхойлолтыг үнэлнэ.
4. Хамтарсан баг болон Нэг цэгийн үйлчилгээний төвийн үр дүнтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх боломжийг судлах, санал боловсруулах
5. Жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлж буй үйлчилгээний талаар олон Улсын туршлагыг судлаж /3-аас доошгүй улсын/ Монгол Улсын хүчирхийлэлтэй тэмцэх үйлчилгээний тогтолцоотой харьцуулсан судалгаа хийнэ.
6. Хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий Нэг цэгийн үйлчилгээний төвөөс Хамтарсан багтай ажиллах үйлчилгээний удирдамж, зааврын төслийг боловсруулна.
7. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах үйлчилгээний удирдамж, зааврын төслийг боловсруулна.
8. Хамтарсан баг болон нэг цэгийн үйлчилгээний ажилтны зүгээс үйлчилгээ үзүүлэхдээ баримтлах нийгмийн ажилтны үнэт зүйлс болон ёс зүйн зарчмын төслийг боловсруулна.
9. Боловсруулалтын явцад мэргэжил арга зүйн зөвөлгөө авах үүднээс холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан нэгээс доошгүй удаа уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулна.

## ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ БҮТЭЭГДЭХҮҮН

Бүх материалыг хэвлэмэл болон электрон байдлаар хүлээлгэн өгнө.

1. Хүчирхийллийн хохирогчдод зориулсан Нэг цэгийн үйлчилгээний төвөөс Хамтарсан багтай ажиллах үйлчилгээний удирдамж, зааврын төсөл.
2. Хүчирхийллийн хохирогчдыг шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах үйлчилгээний удирдамж, зааврын төслийг боловсруулна.
3. НЦҮТ-ийн үйлчилгээ, үйл ажиллагаанд баримтлах үнэт зүйлс, мөрдөх ёс зүйн хэм хэмжээ, ёс зүйн дүрэм зөрчигдсөн эсэхийг талаар дүгнэлт гаргах, хүлээлгэх хариуцлага зэргийг багтаасан ёс зүйн зарчмын төслийг боловсруулах,

## **ЗӨВЛӨХ БАГИЙН ГИШҮҮДИЙН УР ЧАДВАР /СОНГОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД/**

Зөвлөх баг нь дор дурдсан чиглэлээр мэргэшсэн байна:

### **1. Боловсрол:**

- 1) Хүн ам, гэр бүл, жендэр, нийгэм, хууль эрх зүй, нийгмийн ажлын чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх
- 2) Хүн ам, жендэр, нийгэм, гэр бүлийн хөгжил, хамгаалал, нийгмийн ажлын чиглэлээр мэргэшсэн байх.

### **2. Туршлага:**

- 1) Нийгмийн ажлын үйлчилгээний арга зүйн мэдлэг, туршлагатай байх;
- 2) Нийгмийн үйлчилгээтэй холбогдсон журам заавар, удирдамж, арга зүй боловсруулах туршлагатай байх
- 3) Гэр бүл, нийгэм, жендэр, хүчирхийллийн асуудлаар бодлого, хууль, хөтөлбөр боловсруулах ажилд оролцож байсан туршлагатай байх
- 4) Гэр бүл, нийгэм, жендэрийн асуудал, хүчирхийллийн талаар судалгаа, шинжилгээ хийж байсан, зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай байх;
- 5) Дээр дурдсан чиглэлээр 5 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай байх;

### **3. Хэлний ур чадвар:**

- 1) Англи хэлийг мэргэжлийн чиглэлээр хэрэглэх түвшинд эзэмшсэн байх.

### **4. Мэргэжлийн ур чадвар:**

- 1) Журам, заавар, удирдамж, арга зүй, баримт бичиг боловсруулах,
- 2) Баримт бичиг боловсруулахад шаардлагатай судалгаа, дүн шинжилгээ, тооцоог бие даан хийж дүгнэлт гаргах, холбогдох материалыг бүрдүүлэх;
- 3) Удирдамжийн төслүүдийг хэлэлцүүлэх батлуулахад нөлөөлөх;
- 4) Уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, удирдан чиглүүлэх;
- 5) Компьютерын хэрэглээний програмууд дээр чөлөөтэй ажиллах;
- 6) Богино хугацаанд ачаалалтай, бие даан ажиллах, хувийн зохион байгуулалт сайтай байх;
- 7) Холбогдох салбарт ашиг сонирхлын зөрчилгүй байх.

### **Бүрдүүлэх материал:**

- 1) Уг ажлыг хийх сонирхлыг илэрхийлсэн хүсэлт
- 2) Хүсэлт гаргагчийн товч танилцуулга



- 3) Хүсэлт гаргагчийн мэргэжил, мэргэшил, мэдлэгийг нотлохуйц баримтууд, үүнд диплом, сертификат, гэрчилгээний хуулбар
- 4) Ажил гүйцэтгэх төлөвлөгөө

### ХЯНАЛТ, ТАЙЛАГНАЛТ

1. Ажил гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх календарчилсан төлөвлөгөөг боловсруулж захиалагчаар батлуулна.
2. Мэргэжлийн хүмүүсийг оролцуулсан ажлын хэсгийн уулзалтад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, НҮБ-ын Хүн Амын Сангийн төлөөлөл оруулна.
3. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын удирдлага, ажилтнуудтай байнга холбоотой ажиллана.
4. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын дарга, Хүүхэд, залуучууд, ахмад настан, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн дарга нь зөвлөхийн ажлын гүйцэтгэлийн явцад үйл ажиллагаанд нь саад болохгүйгээр ямар ч үед хяналт тавих эрхтэй.
5. Ажлын явцын тайлан болон хүлээлгэн өгөх бүтээгдэхүүнийг төлөвлөгөөний дагуу захиалагч талд танилцуулж, эцэслэн гэрээт хугацаа дууссанаас хойш 7 хоногийн дотор хүлээлгэн өгнө.

### ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

1. 2019 оны 08 дугаар сарын ...-ний өдрөөс ... дүгээр сарын ...-ний өдөр хүртэл нэг сарын хугацаанд ажиллана.
2. Захиалагч байгууллагад нийлүүлэх бүтээгдэхүүнүүдийг бүрэн хүлээлгэн өгсөн ч шаардлагатай үед хамтран ажиллана.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ